

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА  
/ТӨЛӨВЛӨГӨӨ/-НЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/Д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	Авлигаас урьдчилан сэргийлэх, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхол албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах.	1.1. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулах.	Тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг боловсруулан АТГ-т хүргүүлж ажиллалаа.
2	Авлигаас урьдчилан сэргийлэх, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхол албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах.	1.2. Авлигын эсрэг хууль тогтоомжийг албан хаагчид, иргэдэд сурталчилах, энэ тараахи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах.	<p>Тус дүүргийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн ИТХ-ын гаргасан “Авлигын эсрэг хууль тогтоомжийн эмхэтгэл” номыг уг хуулийн үйлчлэлд хамаарах бүх албан хаагчдад тараан гарын авлага болгон өгөв.</p> <p>Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг сурталчилах, албан хаагчдын шударга байдлыг төлөвшүүлэх, ухуулан таниулах чиглэлээр нэгдсэн болон төлөвлөгөөт байдлаар нийт 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 110 албан хаагчдыг хамруулсан болно. Тухайлбал: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчилах сургалтад тус дүүргийн харъяа хэлтэс, албадын болон төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын дарга нар, Тамгын газрын мэргэжилтнүүд, хороодын дарга, нийгмийн ажилтан, зохион байгуулагч зэрэг нийт 110 албан тушаалтан хамрагдав.</p> <p>Мөн Тамгын газрын эрх зүйн мэргэжилтнүүдийн хамтарсан “Төрийн албан хаагчийн дүр төрх” сургалтыг зохион байгуулж, нийт 110-120 албан хаагчдыг хамруулан байна. /Нотлох баримт-1/</p>

3	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох.	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байдал</li> <li>• Дээрх бодлогын баримт бичиг болон шийдвэрийн төсөлд иргэд олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлсэн байх.</li> </ul>	<p>Тус дүүргийн “Нийтийн зар мэдээний журам”, “Хорооны дүрэм”, боловсруулах төсөлд иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж ажилласан. Үүнд: 2014 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Баянзүрх дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэрт орших Католик сүмд болсон. /Энэхүү сүм нь олон хүний багтаамжтай учир сонгосон/ Тус хэлэлцүүлэгт 133 иргэн ирж оролцсон болно. Тооны хувьд цөөн боловч залуучууд голдуу ирж, өөрсдийн санал, шүүмжлэлээ хэлж Хорооны дүрэм, Иргэдийн санаачлагаар санал хураалт явуулах журам, Нийтийн зар мэдээний журмуудын төсөлд санал өгсөн байна. .</p> <p>/Нотлох баримт-2/</p>
4	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах.	<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөлтийн байдал</li> <li>• Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байдал</li> <li>• Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ.</li> </ul>	<p>Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс албад болон харьяа хэлтэс албадаас хийж буй ажил, хяналт шалгалтын талаархи мэдээллийг тухай бүрт нь бэлтгэн дүүргийн болон Засгийн газрын албан ёсны сайтуудад байршуулдаг. Мөн хяналт шалгалтын явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлж, мэдээллийг олон нийтэд хүргэдэг болно. Тухайлбал, Баянзүрх дүүрэгт “Авто үйлчилгээ” эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хамтарсан хяналт шалгалтын ажил явагдаж байгаа талаар, Зочид болон дэн буудлуудад шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг цаг алдалгүй арилгасан талаар гэх мэт мэдээллүүдийг тухай бүрт нь бэлтгэн олон нийтэд хүргэн ажилладаг болно. /Нотлох баримт-7/</p>

5	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаад зээл тусламж, түүний хувиарлалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх.	<ul style="list-style-type: none"> <li>• Жилийн төсөв өмнөх оны төсөвтэй сайтад байрлуулах</li> <li>• Жилийн эцсийн санхүүгийн тайлан цахим самбарт байршуулах</li> <li>• Жилийн төсөвт орсон өөрчлөлтийг байршуулах</li> <li>• Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл нээлттэй байх.</li> </ul>	<p>Тус дүүргийн 2013 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнэлтийг бүрэн эхээр нь, 2013 оны төсвийн орлого зарлагын гүйцэтгэл, 2014 оны батлагдсан төсвийг <a href="http://bzdshilendans.mn">bzdshilendans.mn</a> цахим хуудсанд байршуулан боловсрол, эрүүл мэндийн салбарын болон орон нутгийн нийт 81 төсвийн байгууллага тус бүр дээр “Төсөв санхүүгийн” мэдээллийн самбар ажиллаж төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг тухай бүр шинэчилэн олон нийтэд ил тод нээлттэй мэдээллэн ажиллаж байна.</p> <p>Дүүргийн 2014 оны төсвийн тодотголоор орлогын төлөвлөгөө 71,843,337,8 мянган төгрөг, зарлагын төлөвлөгөө 73,785,583 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд <a href="http://bzdshilendans.mn">bzdshilendans.mn</a>, цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.</p>
6	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах.	<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагаас олгож буй зөвшөөрлийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай бичиг баримтын жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмын нээлттэй байдал.</li> </ul>	<p>Дүүргийн албан ёсны <a href="http://www.bzd.ub.gov.mn">www.bzd.ub.gov.mn</a> цахим хуудаст “Нээлттэй мэдээ” булан ажиллуулан дүүргээс олгож буй зөвшөөрөл, түүнийг олгоход шаардлагатай бичиг баримтын жагсаалтын дэлгэрэнгүй мэдээллийг байршуулсан болно. Тухайлбал: Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээ хийхэд бүрдүүлэх мартериадын жагсаалт, дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний газар ажиллуулах гэрээ хийхэд бүрдүүлэх материалын жагсаалт гэх мэт иргэдэд шаардлагатай мэдээ мэдээллийг дэлгэрэнгүй, ойлгомжтой байдлаар цахим хуудаст байршуулан олон нийтийн цахим сүлжээгээр иргэддээ хүргэн ажиллаж байна.</p> <p>/Нотлох баримт-3/</p>
7	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийт түүнтэй танилцах боломжоор хангах.	<ul style="list-style-type: none"> <li>• Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах</li> <li>• Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсанд ойлгомжтой байдлаар тухай бүр шинэчилэн байршуулах.</li> </ul>	<p>Тус дүүргийн Засаг даргын Тамгын газарт гарсан сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлийн болон дүүргийн цахим хуудсанд байршуулан, зарын дагуу шалгалт өгөхөөр бүртгүүлсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан иргэнийг тухайн албан тушаалд томилон ажиллууллаа.</p> <p>Тайлангийн хугацаанд Ахлах түшмэлийн ажлын байр-2, Дэс түшмэл ажлын байр-4, Туслах түшмэлийн ажлын байр-3-ыг тус тус зарласан байна.</p>

8	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах</li> <li>• Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулсан байдал</li> <li>• Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх</li> <li>• Тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй оролцогчдын талаарх нээлттэй байдал</li> <li>• Худалдан авсан бараа ажил, үйлчилгээний тайланг нээлттэй байлгах</li> <li>• Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээллэх</li> <li>• Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаар нээлттэй байлгах</li> <li>• Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байдал.</li> </ul>	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төлөвлөгөөг батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ гэж заасны дагуу “Нийслэл таймс” сонинд нийтлүүлсэн болно.</p> <p>Тендер шалгаруулалтын талаар болон тендерийн урилгыг <a href="http://www.eprouement.mn">www.eprouement.mn</a>, <a href="http://www.eprouement.ub.gov.mn">www.eprouement.ub.gov.mn</a> сайтууд болон мөн өдөр тутмын “Нийслэл таймс” сонинд тухай бүр байршуулан ажиллаж байна.</p> <p>Худалдан авсан бараа үйлчилгээний талаар 2014 оны 06 дугаар сарын 04-ний өдөр “Ил тод худалдан авах нээлттэй өдөрлөг” дээр иргэдэд брошур болон гарын авлага, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг танилцуулж ажиллалаа.</p> <p>Тендерийн үнэлгээний хороонд оролцох иргэд, салбарын мэргэжилийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан ба тухайлбал тус дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас дараах нэр бүхий иргэдийг 2014 онд Худалдан авах ажиллагааны албанаас зохион байгуулах тендерийн шалгаруулалтын үнэлгээний хороонд ажиллуулахаар томилсон болно.</p> <p>/Нотлох баримт-4/</p>
9	<p>Албан хаагчийн ажил үүргийн хувиарыг тодорхой болгох.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэх</li> <li>• Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг нээлттэй байлгах.</li> </ul>	<p>Төрийн албан хаагч нэг бүрийн ажлын ажлын байрны тодорхойлолтыг мөрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Албан хаагч нэг бүрийн хариуцсан ажил, үүргийн чиглэлийг цахимд байршуулан тавьсан болно.</p>

10	<p>Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах, хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдал, тогтвортой ажиллах нөхцлийг хангах.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрх бүхий албан тушаалтныг томилсон байх</li> <li>• Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтонд тусгасан байх</li> <li>• Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй сургалтанд хамрагдсан байх</li> <li>• Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хангах баталгаа гаргах</li> <li>• Эрх бүхий албан тушаалтны ажлын үр дүнг дүгнэж үзэх</li> <li>• Эрх бүхий албан тушаалтны цалингийн зохих нэмэгдлийг олгож, тогтвортой ажиллуулсан байх.</li> </ul>	<p>Тамгын газрын даргын 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Б/144 тоот тушаалаар эрх бүхий албан тушаалтныг томилсон.</p> <p>Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод тусгасан болно.</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2 удаагийн сургалтад хамрагдаж, 2014 оны 09 дүгээр сарын 22-оос 09 дүгээр сарын 25-ны хооронд зохион байгуулсан 40 цагийн сургалтаар №14/0693 тоот үнэмлэх авсан болно.</p> <p>Хувь хүний нууцтай холбогдсон мэдээ, материалыг хадгалах хамгаалах баталгааг гаргасан ба хадгалалт хамгаалалтын зориулалтаар тусгай цоожтой шкаф хэрэглэдэг болно.</p> <p>Эрх бүхий албан тушаалтныг тогтвортой ажиллуулах зорилгоор цалингийн зохих хувийг Тамгын газрын даргын 2013 оны Б/144 тоот тушаалаар олгож байна.</p> <p>/Нотлох баримт-5/</p>
11	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Ёс зүйн дүрмэнд авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх.</li> <li>• Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулж мөрдүүлсэн байх.</li> <li>• Зөрчлийн талаарх бүртгэл хөтлөлтийн байдал.</li> <li>• Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /зөвлөмж /-г хэрэгжүүлсэн байдал.</li> <li>• Тайлан мэдээг АТГ ирүүлсэн байх.</li> </ul>	<p>Нийслэлийн Засаг даргын 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/419 тоот захирамжаар баталсан “Нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн дүрэм” болон Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулан мөрдүүлэн ажлыг зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагч нэг бүрийн ажлын байрны тодорхойлолтын тусгай тавигдах шаардлагад Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлэх талаар тусгаж өгсөн болно.</p> <p>/Нотлох баримт-6. Нийт 128 албан хаагчийн ажлын байрны тодорхойлолт байх тул баримт болгон 3-н ажлын байрны тодорхойлолт хүргүүлэв./</p>

12	<p>Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар ажил эрхлэж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулах.</li> <li>• Давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмын биелэлт.</li> </ul>	<p>Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7,18,19 дүгээр зүйлийг сурталчилан таниулах, тодорхой ойлголт өгөх зорилгоор сургалт зохион байгуулсан бөгөөд албан хаагчдыг давхар ажил эрхлэлтийн судалгаанд хамруулан судалгааг нэгтгэхэд давхар ажил эрхэлж буй албан хаагч байхгүй байсан болно.</p> <p>/2014 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн сургалтаар албан хаагчдад танилцуулсан болно./ /Нотлох баримт-1/</p>
13	<ul style="list-style-type: none"> <li>• Эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэрийг ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлж цахим хуудас, мэдээлийн самбарт байршуулах.</li> <li>• Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын нээлттэй байдлыг хангах</li> <li>• Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр хураамжийн талаарх мэдээллийн ил тод байдал.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Цахим хуудсанд байршуулсан байх.</li> <li>• Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.</li> </ul>	<p>Эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэрийн тухай бүр цахимд байршуулан ажиллаж байна.</p> <p>Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, тогтоол, дүрэм журмыг bzdshilendans.mn цахим хуудсаны ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ хэсэгт legalinfo.mn цахим хуудсанаас холбоос үүсгэн байршуулсан.</p> <p>Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр хураамж, үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтийг Мэдээллийн самбар болон цахимд ил тод нээлттэй байдлаар байршуулан ажиллаж байна.</p> <p>/Нотлох баримт-7/</p>
14	<p>Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал ажиллах журам, харилцах утас, иргэд хүлээн авах хувиарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх.</li> </ul>	<p>Баянзүрх дүүргийн bzd.ub.gov.mn цахим хуудсанд үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал ажиллах журам, харилцах утас, иргэд хүлээн авах хувиарийг байршуулсан.</p> <p>Өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх явцад байгууллага, нэгж, албан хаагчдын зүгээс гаргасан зөрчлүүдийг тухай бүр бүртгэх, тэдгээрийн ажлын үр дүнг үнэлж дүгнэх хариуцлага тооцоход үндэслэл болгох үүднээс өргөдөл гомдол шийдвэрлэлтийн зөрчлийн тэмдэглэлийг хөтлөн ажиллаж байна.</p>

	дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах, шийдвэрлэх.	<ul style="list-style-type: none"> <li>Иргэдийн өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдлыг мэдээллийн самбарт тогтмол хугацаанд мэдээлсэн байх</li> <li>Ашиг сонирхлын зөрчлийн тараарх мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгаж, хариуцлага тооцсон байдал.</li> </ul>	Мөн долоо хоног бүр Дүүргийн хэлтсүүдийн болон Дүүргийн удирдлагын шуурхай зөвлөгөөнд шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн, хугацааг хэтрүүлж шийдвэрлэсэн хяналтад байгаа өргөдлийн тоон тайлан мэдээг гаргаж танилцуулж байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайланг гарган <a href="http://bzd.ub.gov.mn">bzd.ub.gov.mn</a> цахим хуудсанд улирал бүр мэдээлэн ажиллаж байна.
15	Авлигад өртөх эрсдэлтэй ажил албан тушаал, ажилтны үйл ажиллагааг хянах, урьдчилан сэргийлэх.	<ul style="list-style-type: none"> <li>Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний судалгаа гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх</li> <li>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх хүнд суртал чирэгдэлийг багасгах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэн ажиллуулах арга хэмжээг зохион байгуулах.</li> </ul>	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр ажлын байрны тодорхойлолтод Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлагыг тавьж мөрдүүлэн ажиллахын зэрэгцээ сэлгүүлэн ажиллуулах арга хэмжээг зохион байгуулсан болно.</p> <p>Үүнд: Тамгын газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Б/220 тоот тушаалаар 11 дүгээр хорооны зохион байгуулагчийг 9 дүгээр хорооны зохион байгуулагчаар мөн 10,17 дугаар хорооны Зохион байгуулагчдыг Тамгын газрын даргын 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/328 тоот тушаалаар хооронд нь тус тус сэлгүүлэн ажилласан болно.</p> <p>/Нотлох баримт-6/</p>
16	Зөрчлийн талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар харьяаллын дагуу шилжүүлэх.	<ul style="list-style-type: none"> <li>Авлигатай тэмцэх газар мэдээллийг шилжүүлсэн байна.</li> </ul>	Авлигын зөрчлийн талаарх мэдээлэл ирээгүй байна.
17	Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглох.	<ul style="list-style-type: none"> <li>Судалгаа гаргаж зөрчил гарсан тохиолдолд гэрээ цуцлуулах арга хэмжээг авахуулах.</li> </ul>	Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлаагүй байна.

18	<p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний биелэлт <ul style="list-style-type: none"> <li>• АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний биелэлт</li> <li>• АТГ-ын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбоглох этгээд болон нийтэд өөрийн зардалаар хүргэх арга хэмжээний журам”-ын биелэлт.</li> </ul> </li> </ul>	<p>Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн аргачилалын дагуу 2014 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган батлуулан ажиллаж байна.</p> <p>АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар ирүүлсэн мэдэгдэл байхгүй болно.</p> <p>АТГ-ын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэл ногдуулсан албан тушаалтан байхгүй болно.</p>
<b>Авлигатай тэмцэх санал, санаачлага.</b>			
1	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг арга хэмжээнд зориулсан хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн байдал.</li> <li>• Удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, тэдний үлгэр жишээ байдал.</li> </ul> </li> </ul>	<p>Авлигын эсрэг арга хэмжээг сурталчилах, албан тушаалтанд таниулах зорилгоор зохион байгуулсан сургалтад 553000 төгрөг зарцуулсан байна.</p> <p>/Нотлох баримт-1/</p> <p>Тайлангийн хугацаанд тус дүүргийн удирдлагын зөвлөл нь төлөвлөгөөг болон цаг үеийн шаардлага, тулгамдаж буй асуудлаар нийт 30 удаа хуралдаж асуудлыг хамтын шийдвэрээр шийдвэрлэж хэвшсэн болно.</p>



2		<ul style="list-style-type: none"> <li>• Албан тушаалтан, албан хаагчдын шудрага байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шудрага ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м /-ний үр дүн.</li> </ul>	<p>Албан тушаалтан, албан хаагчдын шудрага байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай” хуулийн таниулах сургалтыг зохион байгуулж ажиллаа.</p> <p>/Нотлох баримт-1/</p> <p>Мөн Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагч нэг бүрийн ажлын байрны тодорхойлолтод Төрийн албан хаачийн ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлэх талаар тусгаж өгсөн болно.</p>
	Албан хаагчдийн шудрага байдал ба түүнийг нэмэгдүүлэх.	<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ</li> <li>• Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ</li> <li>• Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчил.</li> </ul>	<p>Байгууллагын дотоод хяналт, шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил гараагүй байна.</p> <p>Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил гараагүй.</p> <p>Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг, зөрчил гараагүй болно.</p>

ТАЙЛАН ГАРГАСАН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН:

Г.БАТЦЭЦЭГ